

ТАНИЛЦУУЛГА

“Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн төслийн тухай

XXI зуунд олон улсад хайлуур жоншийг стратегийн баялаг гэж үзэн бодлоготойгоор ашиглаж байна. Дэлхийн хайлуур жоншны нийт нөөц баялагийг 500 сая тонн гэж үнэлэгддэг. Монгол улс дээрхи нөөцийн 9 хувийг эзэлж байгаа ч томоохон экспортлогч болж чадахгүй байна. Жонш нь олон улсын биржээр арилжаалагдаггүй металл бус ашигт малтмал. Иймд энэ салбарыг урт хугацаанд дэмжих зохицуулалтын оновчтой тогтолцоог бурдүүлэх шаардлага тулгарч байна.

Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ын 1.2-т: “байгаль орчинд сөрөг нөлөөлэл багатай, дэвшилтээт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх” гэж, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 3.2.2.2-т: “стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялагийг урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь болгон төрийн зохицуулалттай (дээд хэмжээ, татварын зохицуулалт) ашиглах хууль, эрх зүйн орчинг сайжруулах” гэж заасныг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас “Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилтот хөтөлбөр”-ийн төслийн талаар олон нийтийн дунд 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох саналыг авсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь жоншны квот, худалдаа, татварын оновчтой зохицуулалтыг хийж, фортрт нэгдлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих замаар хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалан, хайлуур жоншны үйлдвэрлэлийг улс орны тогтвортой хөгжлийг тодорхойлогч салбар болгон хөгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн хүрээнд 4 зорилтыг дэвшүүлж, зорилт тус бүрт хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон болно.

Хөтөлбөрийг 2018-2023 онд бусад төсөл хөтөлбөрүүдтэй бодлогын уялдаатай хэрэгжүүлнэ. Хайлуур жоншны үйлдвэрлэл нь цемент, хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлтэй цогц хүрээнд үйл ажиллагаа нь явагддаг тул цаашид улс орны үйлдвэржилтийг хөгжүүлэхэд онцгой байр суурийг эзлэх болно.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг уул уурхай, хүнд аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хайлуур жоншны салбарт бизнесийн орчин сайжирч, бүтээгдэхүүний нэр төрөл, өрсөлдөх чадвар, худалдааны эргэлт нэмэгдэн, фторын хүчил, фортрт хөнгөн цагаан үйлдвэрлэгч, экспортлогч улс болно.

2023 оноос фортрт бүтээгдэхүүний жилийн экспортын орлого 350 сая ам долларт хүрч хөтөлбөрийн зорилго биелэгдэнэ.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

“ХАЙЛУУР ЖОНШНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР” /төсөл/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал

Монгол Улс хайлуур жоншны нөөцийн хэмжээгээр Мексик, БНХАУ, ӨАБНУ-ын дараа дэлхийд дөрөвдүгээрт ордог.

Өнөөгийн байдлаар манай улсад 163 орд, 545 илрэлд 122 сая тонн хүдрийн буюу 48.3 сая тонн эрдсийн нөөц бүртгэгдсэн.

Хайлуур жоншны нөөцийн 90 гаруй хувь Төв, Дорнговь, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймагт төвлөрч байна.

Монгол орны хайлуур жоншны флотацийн болон металлургийн баяжмалын үйлдвэрлэлийн хэмжээ 2010 хүртэл тогтвортой өсч, жилийн хүдэр олборлолт 600 мян.тн, металлургийн буюу бүхэллэг жоншны үйлдвэрлэл 402 мян.тн, флотацийн баяжмал үйлдвэрлэлийн хэмжээ 161 мян.тн-д хүрсэн.

Өнөөгийн байдлаар “Монголросцветмет” ХХК-ийн Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэр, “Монголчехметалл” ХХК-ийн Чулуут цагаан дэл, Тэвшийн баяжуулах үйлдвэр болон Айраг, Хажуу-Улаан, Өргөн зэрэг хайлуур жоншны 20 үйлдвэр байгаагаас 9 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, бусад аж ахуйн нэгжүүд зөвхөн баяжуулах үйлдвэр барьж ашиглалтад оруулаад байна.

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу Дорнговь, Дундговь, Хэнтий, Дорнод аймгийн 16 сумын 1086 га бүхий 49 талбайд бичил уурхайн дүгнэлт гарaad байна.

Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортын хэмжээ 2010-2015 онд буурсан боловч 2016 оноос сэргэх хандлагатай байна. Тухайлбал, 2016 онд 248.9 мян.тн жонш экспортод гаргаж, улсын төсөвт 5.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол 2017 онд 319.3 мян.тн жонш экспортолж, улсын төсөвт 10.2 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.

Цаашид хайлуур жоншны нөөцөд түшиглэсэн хими-технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавих, тэргүүн ээлжинд хайлуур жоншны баяжмалыг боловсруулан форт нэгдлүүдийг гарган авах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх нь чухал байна. Мөн жоншны салбарт байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

1.2. Хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д: “Худалдаа, үйлчилгээг хөнгөөвлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршиүүлнэ” гэж;

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.1-д: “Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ” гэж;

Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.5-д: “дотоодын эрдэс баялагийн бүтээгдэхүүний олборлолт, ашиглалт, нөөц бүрдүүлэх чиглэлээр урт, дунд, богино хугацааны хөтөлбөр боловсруулж, мөрдөн ажиллах” гэж;

Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 3.2.2.2-т: “стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялагийг урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь болгон төрийн зохицуулалттай (дээд хэмжээ, татварын зохицуулалт) ашиглах хууль, эрх зүйн орчинг сайжруулна” гэж тус тус заасан нь хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах зарчим

2.1. Хөтөлбөрийн хамрах хүрээ:

- 2.1.1 Үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх геологи хайгуулын ажил
- 2.1.2 Хайлуур жоншны худэр олборлох уулын үйлдвэрлэл
- 2.1.3 Металлургийн баяжмалын үйлдвэрлэл
- 2.1.4 Флотацийн баяжмалаас (ФФ-85-92) хорголж (окатыш), шахмал (брикет) гарган авах үйлдвэрлэл
- 2.1.5 Химийн баяжмалын үйлдвэрлэл
- 2.1.6 Фторт хөнгөн цагааны үйлдвэрлэл
- 2.1.7 Хайлуурын хүчлийн үйлдвэрлэл
- 2.1.8 Хайлуур жоншны дотоодын худалдаа, нийлүүлэлт
- 2.1.9 Фторт бүтээгдэхүүний экспорт

2.2. Хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг 2018-2023 онд холбогдох бусад төсөл, хөтөлбөртэй уялдаатай хэрэгжүүлнэ.

2.3. Баримтлах зарчим:

- 2.3.1 тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн, дэвшилтэй техник, технологид суурилсан байгалийн нөөцийн хэмнэлтэй, экспортын чиг баримжаатай, үйлдвэрлэлийг дэмжих;
- 2.3.2 төр, шинжлэх ухаан, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах;

2.3.3 мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын шударга өрсөлдөөнийг дэмжих зэрэг зарчмыг баримтлана.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилто:

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хайлуур жоншины квот, худалдаа, татварын оновчтой зохицуулалтыг хийж, фортрт нэгдлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих замаар хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, үндэсний үйлдвэрлэгчдийг хамгаалан, хайлуур жоншины үйлдвэрлэлийг улс орны тогтвортой хөгжлийг тодорхойлогч салбар болгон хөгжүүлэхэд оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилтууд:

Зорилт 1. Хайлуур жоншины нөөцийг баталгаажуулж, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

Зорилт 2. Гарал үүслийн гэрчилгээ олгох болон татвар төлөлтийн тогтолцоог боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлэх;

Зорилт 3. Үндэсний баяжуулах үйлдвэрүүдэд стандартад нийцсэн жоншины хүдэр нийлүүлэлтийг урт хугацаанд тогтвортой хангах, худалдаа, экспортыг хөнгөвчлөх тогтолцоог шинээр бий болгох;

Зорилт 4. Дэвшилтэт техник, технологид сууринсан фортрт нэгдлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг төрийн бодлогоор дэмжих;

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Зорилт 1. Хайлуур жоншины нөөцийг баталгаажуулан, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

4.1.1. Хайлуур жоншины геологийн нөөцийг хянан магадалж, нөөцийн хөдөлгөөнийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, нөөцийн эдийн засгийн үнэлгээг хийж тайлгах;

4.1.2. Үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх, гүнд хүдрийн биетийг илрүүлэх геологи хайгуулын ажлыг цаашид үндсэн чиглэл болгох;

4.1.3. Уулын ажлын төлөвлөгөө, мэдээ тайлан ирүүлдэггүй олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хуульд заасан хариуцлагыг тооцож хэвших;

4.1.4. Нөөц нь батлагдаагүй талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдэд 2020 он хүртэл хугацаа олгож, цаашид хуульд зааснаар хариуцлага тооцох;

4.1.5. Далд аргаар хүдэр олборлох техник, технологийг боловсронгуй болгож, уурхайн олборлолтыг мэргэжлийн оператор компани гэрээгээр гүйцэтгэдэг тогтолцоог бий болгох;

4.1.6. Нөөцийг бүрэн ашиглах талаар Мэргэжлийн холбоодоос нөхөрлөл, бичил уурхайд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, цаашид компанийн зохион байгуулалтанд шилжүүлэх;

4.1.7. Нөөц бага ордуудыг ашиглах асуудлыг техник технологи, аюулгүй ажиллагааг хангасан уурхайн нэг загварын зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

4.1.8. Хайлур жоншны олборлох, баяжуулах, химиин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах ажлыг эрх бүхий үндэсний аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагаар тэргүүн ээлжинд хийж гүйцэтгүүлэх;

4.1.9. Үйлдвэрлэлийн технологийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага болон мэргэжлийн холбоодын хүчээр хамтарсан хэлбэрээр гүйцэтгүүлэх;

Зорилт 2. Гарал үүслийн гэрчилгээ олгох болон татвар төлөлтийн тогтолцоог боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлэх;

4.2.1. Хайлур жоншны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн байршил, үйл ажиллагааны чиглэлүүдийг аймаг, орон нутагтай хамтран нарийвчлан тогтоож, улсын бүртгэл, статистик мэдээнд бүрэн хамруулах;

4.2.2. Экспортолж байгаа бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээ олгох тогтолцоог боловсронгуй болгож мэргэжлийн холбоодод хариуцуулах;

4.2.3. Хайлур жонш, баяжмал, бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тогтоох, жишиг үнийг зарлах тогтолцоог боловсронгуй болгож, татварыг шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой тооцох талаар судалгааны ажил хийж, Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх;

4.2.4. Дэлхийн зах зээл дээр хайлур жоншны үнийн өсөлт, бууралтын эрсдлээс үндэсний үйлдвэрлэгчдээ хамгаалах санхүүгийн арга хэрэгсэл ашиглах;

4.2.5. Удирдлагын тогтолцооны OSHAS18001:2012 болон ISO 50000 стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах;

Зорилт 3. Үндэсний баяжуулах үйлдвэрүүдэд стандартад нийцсэн жоншны худэр нийлүүлэлтийг урт хугацаанд тогтвортой хангах, худалдаа, экспортыг хөнгөвчлөх тогтолцоог шинээр бий болгох;

4.3.1. Кальцитийн өндөр агууламжтай худэр боловсруулах технологийг нутагшуулах, нэвтрүүлэх;

4.3.2. Хайлур жоншны худэр түүхийгээр экспортод гаргахыг 2019 оноос бүрмөсөн хориглох эрх зүйн орчинг бий болгож, үйл ажиллагаа явуулж байгаа баяжуулах үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг 2020 онд

30 хүртэл хувьд, 2023 онд 70 хүртэл хувьд хүргэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;

4.3.3. Худалдаа, ложистик сүлжээг хөгжүүлэн экспортын барааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн экспортын квот тогтоох журам боловсруулж мөрдүүлэн, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 15 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах;

4.3.4. Хайлур жоншны балансын бус хүдрийн овоолго, хаягдлын нөөцийг тогтоож, улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтаар ашиглаж, дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлэх тогтолцоог бий болгож мөрдүүлэх;

4.3.5. Эрдэс түүхий эдийг иж бүрэн ашиглах зорилгоор баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаягдлыг барилгын материал зэрэгт ашиглах туршилт, судалгааны ажлыг хийж гүйцэтгэх.

4.3.6. Бүтээгдэхүүний чанар, стандартад тавих хяналтыг сайжруулах, нэгдсэн терминал байгуулах, гадаад худалдаанд эцсийн худалдан авагчидтай харилцаж үйлчилгээ үзүүлэх худалдааны мэргэшсэн компанийг байгуулах замаар , ложистик, экспортын “Нэг цонх”-ны бодлогыг хэрэгжүүлэх;

4.3.7. Бор-Өндөр, Чойр зэрэг дэд бүтэц хөгжсөн бус нутгийг түшиглүүлэн хайлур жоншны бүтээгдэхүүнийг борлуулах, экспортлох нэгдсэн терминал байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;

4.3.8. Бэрх, Чулуут цагаан дэлийн ордуудыг түшиглэн баяжуулах үйлдвэр барих асуудлыг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж, судалж шийдвэрлэх;

4.3.9. Хайлур жоншны хүдрийг ангилан ялгах оновчтой технологи бүхий нэг загварын техник тоног төхөөрөмжийг судалж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хөнгөлөлтэй нөхцлөөр олгох.

Зорилт 4. Дэвшилтэй техник, технологид суурилсан форт нэгдлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг төрөөс бодлогоор дэмжих;

4.4.1. Инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гарган авах судалгаа, патент, оюуны өмчийн эрх, экспортонд нийлүүлэгдэх форт хөнгөн цагааны үйлдвэрлэлийн төслүүдийг “Үйлдвэржилтийг дэмжих сан”-гаас санхүүжүүлэх;

4.4.2. Форт нэгдлийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэр барьж байгуулахад өндөр хөгжилтэй улс орнуудаас техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээг авч ашиглах;

4.4.3. Гадаад улс орнуудын экспортын агентлагаар дамжуулан олгодог техник, тоног төхөөрөмжийн зээлийн нөхцлийг хөнгөвчлөх асуудлыг судалж хэрэгжүүлэх;

4.4.4. Форт нэгдлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдэд ашиглагдах техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, урвалж материалыг гааль, нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөх асуудлыг судлан шийдвэрлэх;

4.4.5. Форт нэгдлийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг 10 жил хүртэл хугацаанд газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судлан шийдвэрлэх;

4.4.6. Хайлуур жоншны баяжмалын гүн боловсруултыг зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийн явцтай уялдуулж, Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрийн дэд бүтцийг түшиглэн форт нэгдлүүд үйлдвэрлэх;

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Үндэсний хөтөлбөр нь 2018-2023 оны хооронд хэрэгжих бөгөөд 2018 оныг сурь он болгож, дараах үр дүн, шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Үүнд:

- Хайлуур жоншны хүдрийн баталгаат нөөц нэмэгдэнэ.
- Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэл хөгжиж, салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
- Гарал үүслийн гэрчилгээ олгох, татвар төлөлтийн шударга тогтолцоо бүрдэж, хайлуур жоншны салбарт бизнесийн орчин сайжирна.
- Баяжуулах үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт нэмэгдэж, урт хугацаанд стандартад нийцсэн түүхий эд, материалаар тогтвортой хангах цогц сүлжээ бүрдсэн байна.
- Худалдаа, экспортыг хөнгөвчлөх шинэ тогтолцоо бий болно.
- Зах зээлийн үнийн өөрчлөлтийн эрсдлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.
- Бага агуулгатай жоншны хүдэр баяжмалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж зах зээлд нийлүүлэгдэнэ.
- Гангийн үйлдвэрүүдийг стандартад нийцсэн хайлуур жоншоор урт хугацаанд тогтвортой хангах сүлжээ бүрдсэн байна.
- Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрээс ялгарах хүхрийн хүчлийн үндсэн хэрэглэгч болно.
- Олон улсын стандартын шаардлага хангасан форт нэгдлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, экспортлогч орон болно.
- 2023 оноос форт нэгдлийн бүтээгдэхүүний жилийн экспортын орлого 350 сая амдолгарт хүрч хөтөлбөрийн зорилго биелэгдэнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу хагас, бүтэн жилээр үнэлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр

6.1. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусlamж;

6.1.3. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;

6.1.4. хөгжлийн банк, арилжааны банкны зээлийн хөрөнгө;

6.1.5. үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө;

6.1.6. бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг уялдуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох байгууллагууд хамтран гүйцэтгэнэ.

7.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга, холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр гүйцэтгэх ба мэргэжлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтарч ажиллана.

8.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга, холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт танилцуулна.

8.4. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

--- оОо ---